



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/571

Булган сум

### Мал угаалгын ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга, ерөнхий малын эмчийн 2023 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал эмнэлгийн төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх, малын амьтныг шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мал угаалгын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс зохион байгуулсугай.

2. Сумын мал эмнэлэг, малын эмч нарыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), мал угаалгын ажлыг орон нутагт зохион байгуулан удирдлага, хүн хүч, машин техник, бусад шаардлагатай зүйлээр хангаж, малчид, багийн дарга нарыг үүрэгжүүлэн ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Мал угаалгын ажлын арга хэмжээг зохион байгуулсан дүн мэдээг нэгтгэн 2023 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад танилцуулахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



6323010624